



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 290

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.2.3, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Налайхын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон нийт 132,706,600.00 (нэг зуун гучин хоёр сая долоон зуун зургаан мянга зургаан зуун төгрөг) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Налайхын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Минжинхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулна
2019 оны 07 дугаар сарын 22
20... дугаар тогтоол

**"Налайхын дулааны станц" төрийн өмчит хувьцаат компанийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

Хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон огноо	Хэм жих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/
ж үлээх салхилуур	10/1/1995	ш	3	1,200,000.00	3,600,000.00	3,600,000.00
куляцийн насос	10/1/1995	ш	3	1,000,000.00	3,000,000.00	3,000,000.00
лтийн усны насос	10/1/1995	ш	2	40,000.00	80,000.00	80,000.00
станцын насос	10/1/1995	ш	2	90,000.00	180,000.00	180,000.00
үүлжээний насос	10/1/1995	ш	1	1,600,000.00	1,600,000.00	1,600,000.00
н нэмэлт насос	10/1/1995	ш	2	350,000.00	700,000.00	700,000.00
эмэлт усны насос	10/1/1995	ш	1	160,000.00	160,000.00	160,000.00
асан усны насос	10/1/1995	ш	2	805,000.00	1,610,000.00	1,610,000.00
йн насос	10/1/1995	ш	1	1,250,300.00	1,250,300.00	1,250,300.00
ч	10/1/1995	ш	1	4,000,000.00	4,000,000.00	4,000,000.00
врын зуух-1	10/1/2002	ш	2	22,392,000.00	44,784,000.00	44,784,000.00
врын зуух-3	12/1/2003	ш	1	9,207,000.00	9,207,000.00	9,207,000.00
гаан соронзон шкив	10/1/1995	ш	1	80,000.00	80,000.00	80,000.00
ширээ	7/1/2001	ш	1	500,000.00	500,000.00	500,000.00
р хэмжигдэхүүн №1	10/1/1995	ш	8	72,400.00	579,200.00	579,200.00
м дулааны тоолуур	1/1/2000	ш	1	1,457,000.00	1,457,000.00	1,457,000.00
насос	11/25/2009	ш	2	12,425,500.00	24,851,000.00	24,851,000.00
усмалын бак	10/1/1995	м3/цаг	1	160,000.00	160,000.00	160,000.00
усгагч	10/1/1995	м3/цаг	1	70,000.00	70,000.00	70,000.00
асос	11/25/2009	муб	1	20,180,000.00	20,180,000.00	20,180,000.00
өрөмдмөл	11/6/2000	ш	1	10,000,000.00	10,000,000.00	10,000,000.00
ын төмөр хашаа	1/1/1976	ш	1	2,803,000.00	2,803,000.00	2,803,000.00
/Axis 211M nnn network/	12/30/2009	ш	1	1,530,850.00	1,530,850.00	1,530,850.00

Хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон огноо	Хэм жих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/
/Full outdoor installation per/	12/30/2009	ш	1	324,250.00	324,250.00	324,250.00
Нийт дүн			41	91,697,300.00 (ерэн нэгэн сая зургаан зуун ерэн долоон мянга гурван зуун)	132,706,600.00 (нэг зуун гучин хоёр сая долоон зуун зургаан мянга зургаан зуун төгрөг)	132,706,600.00 (нэг зуун гучин хоёр сая долоон зуун зургаан мянга зургаан зуун төгрөг)